

ХААЛГА ба ЗАМ

Санваарын ёслолууд болон гэрээнүүд биднийг мөнх амьдралын зам дээр гаргаж, яг одоо бидэнд хэрэгтэй байгаа хүч чадлаар биднийг адисалдаг.

Бид бүгд мөнх амьдралыг эрэлхийлдэг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, бид Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд гэр бүлтэйгээ амьдарч чадах селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд аврагдаж, өргөмжлөгдөх болно гэсэн үг.

Нэмж хэлэхэд, Есүс Христэд итгэх итгэл, наманчлал мөн санваарын ёслолууд болон гэрээнүүд нь мөнх амьдрал өөд хөтөлдөг зам дээр гарах боломжийг бидэнд олгодог. Та сүмийн гэр бүлд төрсөн юм уу хожим хөрвөсөн эсвэл та бүх амьдралынхаа туршид идэвхтэй байгаа эсэх мөн сүмийн үйл ажиллагаанд саяхан эргэж ирсэн эсвэл таны энэ зам дээр хэзээ гарсан болон одоо энэ зам дээр хаана байгаа тань хамаагүй бөгөөд харин та гэрээнүүдэд болон тэдгээрийг хүлээн авч сахихад анхаарлаа төвлөрүүлбэл замын дагуу өсч хөгжиж чадна.

Санваарын ёслолууд болон гэрээнүүд нь зөвхөн алдар суут ирээдүйн амлалтыг санал болгодоггүйг мэдэх нь чухал юм. Эдгээр нь замыг дагаж, зөв шударга байдалд эцсээ хүртэл тэвчихийн тулд яг одоо бидэнд хэрэгтэй байгаа хүч чадал, тайтгарал ба дэмжлэгийг өгдөг. ■



"Сүм дэх санваарын эрх мэдлээр гэр бүлүүдийг хамтад нь холбож, бидний хүн нэг бүрийг селестиел хаант улсад Бурхан Эцэг, Есүс Христ хоёрт

эргэж очиход тэнцэхүйц болоход шаардлагатай ариун нандин ёслолууд болон гэрээнүүдийг хийдэг. Эдгээр ёслолууд нь Их Эзэнтэй хийдэг гэрээнүүд учраас амар амгаланг авчирдаг билээ."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Квинтин Л.Кук, "Хувь хүний амар амгалан: зөв шударга байдлын шагнал," *Лиахона*, 2013 оны 5-р сар, 34.



БАПТИСМ

Бид ариун ёслолоор баптисмын гэрээгээ долоо хоног бүр шинэчилдэг

АРИУН СҮНСНИЙ БЭЛЭГ



Хаалга

МӨНХ АМЬДРАЛ ӨӨД ХӨТӨЛДӨГ ЗАМ (ЭЦСЭЭ ХҮРТЭЛ ТЭВЧИХ)

2 Нифай 31-р бүлгийг үзнэ үү



"Сайн мэдээний гэрээ, зарлигууд болон ёслолуудын зам дээр байх нь биднийг хамгаалж мөн энэ дэлхийд Бурханы ажлыг хийхэд биднийг бэлтгэдэг."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс, "Ариун газруудад бат зогсогтооё," *Лиахона*, 2013 оны 5-р сар, 49.



"Та нар санваарын ёслолуудад зохистой оролцох үед Их Эзэн та нарт агуу хүч чадал, амар амгалан болон мөнх амьдралын найдварыг өгөх болно."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсен, "Санваар дахь хүч," *Лиахона*, 2013 оны 11-р сар, 95.

МӨНХ АМЬДРАЛ (ГЭР БУЛУУД БҮХИЙ СЕЛЕСТИЕЛ ХААНТ УЛС)

ЗАМЫН ДАГУУХ ТУСЛАМЖУУД

Судрууд—Бурхан болон Түүний хүмүүсийн хооронд байгуулсан гэрээний хэсэг болж хүлээн авагдсан удирдамж ба заавар юм (С ба Г 84:57-г үзнэ үү)

Залбирал—"[Их Эзэн] бидэнд 'үргэлж Түүнийг санах гэрээг санал болгож, бид Түүнд итгэл найдвараа тавих нь бидний цорын ганц аюулгүй байдал учраас 'үргэлж залбирч байхыг' анхааруулсан юм" (Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, "Always (Үргэлж)," *Ensign*, 1999 оны 10-р сар, 9-р хуудас).

Үйлчлэл—бид Бурханд болон Түүний хүүхдүүдэд үйлчилснээр, түүний дотор дуудлагуудаа биелүүлж, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил хийснээр, сайн мэдээг хуваалцаж, бүрэн цагийн номлолын үйлчлэл хийснээр гэрээнүүдэд биелүүлж байгаа явдал мөн

Наманчлал—бид зөв замаас гажсан үед заримдаа санваарын удирдагчдаас тусламж аван гэрээнүүдэд санаж, Аврагчид улам ойртох үйл явц мөн

АРИУН СҮМИЙН ЛАЦДАН ХОЛБОЛТ



АРИУН СҮМИЙН ХИШИГ

Өвчтөнд өгдөг адислалууд—тусламж ба эдгээлт



Хэрэгцээтэй үед өгдөг Эцэгийн адислалууд мөн тайтгарлын бусад адислалууд ба зөвлөгөө

АМИН ЧУХАЛ ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД ШИНЭЧЛЭГЧ БА ХҮЧИРХЭГЖҮҮЛЭГЧ ЁСЛОЛУУД

Патриархын адислал бол хувь хүнд зориулсан удирдамж ба амлагдсан адислалууд мөн.

САНВААР ХҮРТЭЭХ БОЛОН САНВААРТ ТОМИЛОХ НЬ (ЗАЛУУ ЭРЭГТЭЙЧҮҮДЭД)

